



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 3/13

Улаанбаатар хот

«Дагвасамбуугийн Энхтайваныг цэргийн алба»  
хаасны тэтгэвэр тогтоолгохоор албан тушаалаас  
чөлөөлөх тухай

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.1.5, 280 дугаар зүйлийн 280.2, 286 дугаар зүйлийн 286.7, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч Дагвасамбуугийн Энхтайван нь цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тул 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон албан тушаалаас нь чөлөөлсүгэй.

2. Д.Энхтайваныг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл цэргийн албанд биеэр 19 жил 11 сар 02 хоног, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласан хугацааны нэмэгдэл 02 жил 07 сарыг нэмж тооцон, цэргийн албанд нийт 22 жил 06 сар 02 хоног ажилласнаар тооцсугай.

3. Д.Энхтайванд 36 (гучин зургаа) сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн мөнгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар (хурандаа С.Батбямба)-т зөвшөөрсүгэй.

4. Д.Энхтайваны ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоо хийхийг Захиргааны удирдлагын газар (хурандаа Ч.Нэргүй)-т даалгасугай.

ДАРГА, ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН:  
Захиргааны удирдлагын  
газрын дарга, хурандаа  
2022.01.25



Д.ЗАГДЖАВ

Ч.Нэргүй